Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа
БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2026 оны 09 дүгээр сар)

Сөүл хот, 2026 он.

ГАРЧИГ

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ IX САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН 3

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ 3
   1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил 3
      1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол 3
      1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол 5
      1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ 6
      1.1.4. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихийг дэмжих үйлчилгээ 7
   1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгаалллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр) 7
      1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо 7
      1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт 8
      1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт 8

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ 10
   2.1. Нийгмийн хамгаалллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ 10
   2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд 10
   2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ 10
   2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр) 11

ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ 13
   3.1. Сургалт сурталчилгаа, явуулын үйлчилгээ 13
   3.2. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил 14

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2026 ОНЫ IX САРД ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн үйл ажиллагаа нь Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр, хоёр улсын холбогдох яамдын хооронд байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд хэрэгждэг.

Тус төв нь БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээг, гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд шаардлагатай төрийн үйлчилгээг хүргэх чиг үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага юм.

2026 оны IX сард төвийн дүрэм, хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэг, эрхлэх асуудлынхаа хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, иргэдэд хүргэсэн төрийн үйлчилгээг (хөдөлмөр, нийгмийн хамгаалал болон нийгмийн даатгалын чиглэлээр ангилж) энэхүү тайланд дурьдав.

1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.09.01 - 2026.09.30)

1.1. Ажиллах хүч илгээх санамж бичгийн хэрэгжилтийг хангаж, хөдөлмөрийн харилцаатай холбоотой гүйцэтгэсэн ажил

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасаг нь 2026 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр танхим, цахим, утас болон факсаар хандсан нийт 117 иргэний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйлчилгээ үзүүлэн, өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажиллав.

Тус ажлын үр дүнд БНСУ-ын Самсунг даатгалын оршин суух хугацаа дуусгавар болсны даатгал - 42,265,380 вон, нутаг буцах зардал - 8,000,000 вон, үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө - 7,030,673 вон, илүү цагийн хөлс -15,518,684 вон, олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс - 7,752,000 вон, 13 дахь сарын цалин - 72,944,841 вон, эмнэлгийн үнэ төлбөргүй үйлчилгээ 930,000 вон зэрэг нийт **149,511,578 вон**ыг Монгол Улсын **37** иргэнд (давхардсан тоогоор) олгуулав.

1.1.1. Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар хөдөлмөрийн гэрээт ажилчдад хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

Иргэн Г.А-гийн (E-9) нутаг буцах зардал, 13 дахь сарын цалинг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулах хүсэлтийг гаргасан.

Иргэн Б.С-ийн (E-9) олгогдоогүй цалин хөлсний тодорхойлолтыг авч Хөдөлмөр халамжийн газар болон Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газраас 4,286,080 вонын цалин хөлсийг нэхэмжлэх хүсэлтийг гарган олгуулсан.

Иргэн Ц.З-гийн (E-9) нутаг буцах зардал 500,000 вон, 13 дахь сарын цалин 2,434,600 вон, нийт 2,934,600 воныг Самсунг даатгалын газраас нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Н.Б--гийн (E-9) нутаг буцах зардал 500,000 вон, 13 дахь сарын цалин 8,498,600 вон, нийт 8,998,600 воныг Самсунг даатгалын газраас нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Г.Б--гийн (E-7-4) үйлдвэрийн зөрүү олгох хүсэлтийг хүлээн авч 3,913,380 вон олгуулсан.

Иргэн Э.М-ийн (E-9) нутаг түр буцах хугацаанд ажил олгогчоос хөдөлмөрийн гэрээг сунгаагүй, ажлаас халсан гэх өргөдлийг хүлээн авч Цагаачлалын албаны хүний эрх, эрх ашгийг хамгаалах багт 2026.06.11-ний өдөр, ажлаас үндэслэлгүй халсан талаарх гомдлыг боловсруулан 경기지방노동위원회-д 2026.06.26-ний өдөр тус тус гомдлыг гаргасан.

Иргэн М.Ө--гийн (E-9) нутаг буцах зардал 500,000, Самсунг даатгалын 13 дахь сарын цалин 2,540,000 нийт 3,175,040 воныг олгуулсан.

Иргэн Ч.Г-гийн (E-7) нутаг буцах зардал 500,000, Самсунг даатгалын 5,403,300 воныг олгуулахаар Самсунг даатгал руу материалыг илгээсэн.

Иргэн Б.Д--гийн (E-9) нутаг буцах зардал Самсунг даатгалын 13 дахь сарын цалинг олгуулахаар Самсунг даатгалын газарт өргөдөл гарган нэхэмжилсэн.

Иргэн Т.Д-гийн (E-9) 13 дахь сарын цалин 6,004,800 вон, нутаг буцах замын зардал 500,000 вон, нийт 6,504,800 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Ч.Э-гийн (E-9) 13 дахь сарын цалин 5,863,950 вон, нутаг буцах замын зардал 500,000 вон, нийт 6,363,950 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Э.С-ийн (E-9) 13 дахь сарын цалин 4,002,300 вон, нутаг буцах замын зардал 500,000 вон, нийт 4,502,300 воныг Самсунг даатгалаас нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Г.М-ийн (E-9) нутаг буцах замын зардал 500.000 вон, 13 дахь сарын цалин хөлс болох 2,261,700 вон, нийт 2,761,700 воныг олгуулав.

Иргэн А.Г-гийн (E-9) 2024.05.25-наас 2026.06.25-ны өдрийг хүртэлх ажилласан хугацааны илүү цагийн хөлсийг тооцон, ажил олгогчоос 3,736,325 воныг нөхөн олгуулав.

Иргэн А.Б-гийн (E-9) 2024.05.25-наас 2026.06.25-ны өдрийг хүртэлх ажилласан хугацааны илүү цагийн хөлсийг тооцон,ажил олгогчоос 2,802,249 воныг нөхөн олгуулав.

Иргэн С.А-гийн (E-9) 2024.05.25-наас 2026.06.25-ны өдрийг хүртэлх ажилласан хугацааны илүү цагийн хөлсийг тооцон, ажил олгогчоос 4,694,030 воныг нөхөн олгуулав.

Иргэн Л.Э-гийн (E-9) 13 дахь сарын цалинг Самсунг даатгалын газраас нэхэмжлэн 4,531,800 воныг олгуулж, мөн үйлдвэрийн 13 дахь сарын цалингийн зөрүү болох 1,119,973 воныг ажил олгогчоос нэхэмжлэн тус тус олгуулж шийдвэрлэв.

Иргэн О.Т-гийн (E-7-4) 13 дахь сарын цалин 13,705,743 воныг ажил олгогчоос олгуулж шийдвэрлэв.

Иргэн Г.Ц--гийн (E-7-4) 13 дахь сарын цалин 14,542,425 воныг ажил олгогчоос олгуулж шийдвэрлэв.

Иргэн Д.Б-гийн (E-9) үйлдвэрийн 13 дахь сарын цалингийн зөрүү болох 1,997,320 воныг Самсунг даатгалын газраас нэхэмжлэн олгуулж, ажлын байр солих асуудлыг тус тус шийдвэрлэв.

Иргэн М.Б--гийн (E-9) ажил олгогчоос хуульд заасан хугацаанд цалин хөлсийг олгоогүй тул 충주고용노동지청-д цалингийн гомдлыг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр гаргаж, Хөдөлмөрийн хэлтэст орчуулагчаар ажиллав.

М.С-ийн (E-9) ажлын байрны дарамттай холбоотой өргөдлийг хүлээн авч, ажлын орчин, нөхцөлтэй танилцах, ажил олгогчтой үүссэн асуудлыг шийдвэрлэхээр Өмнөд Чүнчон аймгийн ..... хотын нутаг дэвсгэрт байрлах ..... хувцас дахин савлах үйлдвэрт очиж ажиллав.

1.1.2. Бусад төрлийн визтэй болон визгүй оршин сууж буй иргэдэд хүргэсэн үйлчилгээ, шийдвэрлэсэн өргөдөл гомдол

Иргэн Л.Р-ийн (визгүй) олгогдоогүй хойшлогдсон цалин хөлсний гомдлыг 화성고용노동지청-д гарган 2,622,000 воныг олгуулав.

Иргэн Ч.О-гийн (визгүй) ажлаас гарсны дараах тэтгэмж 6,649,746 олгуулах хүсэлтийг хүлээн авч, тооцооллыг хийн ажил олгогчтой тохиролцоогүй тул 구미고용노동지청-д өргөдлийг гаргаж 3,000,000 воныг олгуулсан.

Иргэн Н.Б-гийн (визгүй) 13 дахь сарын цалин олгуулах хүсэлтийг 2026.06.05-ны өдөр хүлээн авч, 중부지청-д өргөдлийг гарган ажил олгогчоос 5,000,000 вон олгосон.

Иргэн Б.Н-ийн (визгүй) үйлдвэрлэлийн осолд өртөж ажилгүй байсан үеийн цалин хөлсийг нэхэмжлэх гомдлыг 2026.06.05-ны өдөр хүлээн авч Каннам болон Чонан Хөдөлмөр халамжийн хэлтэст 9 удаагийн хүсэлтийг гарган 10,860,620 воныг олгуулаад байна.

Иргэн О.Б--гийн (визгүй) олгогдоогүй цалин хөлс 4,000,000 вон олгуулах хүсэлтийг 2026.03.18-ны өдөр хүлээн авч 목포고용노동지청-д гомдлыг гаргасан. Ажил олгогчтой тохиролцон 2,130,000 вон олгосон.

Иргэн Э.Т-гийн (визгүй) 13 дахь сарын цалин олгох хүсэлтийг хүлээн авч, 서울동부고용노동지청-д өргөдлийг гарган ажил олгогчоос 1,755,078 вон олгосон.

Иргэн О.А-гийн (визгүй) олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс 940,000 вон олгох хүсэлтийг 2026.09.08-ны өдөр хүлээн авч 서울북부지청-д гомдлыг гаргав.

Иргэн Г.Б-гийн (D-4) олгогдоогүй цалин хөлс 2,690,000 вон олгуулах хүсэлтийг хүлээн авч 평택고용노동지청-д 2025.06.18-ны өдөр өргөдлийн бүрдүүлбэрийг ханган шилжүүлэв. Шүүхээр асуудлыг шийдвэрлэхээр өргөдөл гаргагчийг хүлээсэн ч тодорхойлолт ирүүлээгүй, холбогдох боломжгүй байгаа тул өргөдлийг хаав.

Иргэн Б.Б, Б.Ш нарын олгогдоогүй цалин хөлс 320,000 вон олгуулах хүсэлтийг хүлээн авч 대전지방고용노동지청-д өргөдлийг гаргасан ч өргөдөл гаргагчаас 2 удаа дуудахад очоогүй тул өргөдлийг Хөдөлмөрийн хэлтсээс хаасан.

Иргэн Ц.О-гийн (визгүй) E-9 визээр ажиллаж байсан үеийн нутаг буцах зардлыг АҮХНГ-аас нэхэмжилсэн боловч банкны мэдээллийн улмаас буцсан, Монгол дахь eps төвөөр дамжуулан нэхэмжлэх болсон тул өргөдлийг хаав.

Иргэн Б.Г, Г.Г, Ж.Т (визгүй) нарын сайн дураар нутаг буцах хүсэлтийг хүлээн авч мэдэгдлийг гаргаж өгсөн.

Иргэн А.А-гийн (визгүй) үйлдвэрлэлийн осолд өртсөн талийгаачийн ар гэрт олгох нөхөн олговрын хүсэлт, материалыг бүрдүүлэн 근로복지공단 강릉지사-д 2025.06.17-нд хүргүүлсэн. Хөдөлмөр халамжийн хэрэг эрхлэх газраас ирүүлсэн цагийн тооцоолол болон ослын үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг бөглөн 2025.12.15-нд ХХХЭГ-т (ksptpt@kcomwel.or.kr) хүргүүлэн, өргөдлийг Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-нд шилжүүлсэн тул өргөдлийг хаав.

Иргэн Э.У (визгүй) 2024-2026 оны хугацаанд ажилласан үйлдвэрээс авах 13 дахь цалин 3,500,000 воныг нэхэмжилсэн өргөдлийг хүлээн авч хөдөлмөрийн хэлтэст илгээн 3,817,125 воныг олгуулсан.

Иргэн Б.А-гийн (G-1) 2023-2026 онд ажилласан үеийн үйлдвэрээс авах 13 дахь сарын цалин 2,500,000 воныг олгуулсан.

Иргэн Н.Ц-гийн (визгүй) ажилласан үеийн 13 дахь сарын цалин болох нийт 15,623,870 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Б.А-гийн (визгүй) олгогдоогүй цалин болох нийт 3,000,000 воныг ажил олгогчоос нэхэмжлэн олгуулсан.

Иргэн Ж.Ө-гийн (визгүй) ажилласан үеийн 13 дахь сарын цалинг ажил олгогчоос нэхэмжлэх өргөдлийг өргөдөл гаргагчийн хүсэлтийн дагуу хаасан.

Иргэн Г.С-ийн (G-1) хоёр байгууллагаас олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс олгуулах өргөдлийг хүлээн авч нь нэг өргөдлийг 성남고용노동지청-д гарган ажиллаж байна.

Иргэн Б.Ү-гийн (визгүй) хоёр байгууллагаас олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс олгуулах өргөдлийг хүлээн авч нь өргөдлийг 고용노동부 부천고용노동청-д гарган ажиллаж байна.

Иргэн А.Г-гийн (визгүй) 13 дахь сарын цалин олгуулах хүсэлтийг хүлээн авч 13,000,000 воныг ажил олгогчоос олгуулж шийдвэрлэв. Мөн Самсунг даатгалын газарт байршсан үйлдвэрийн 13 дахь сарын цалин болох 6,126,730 воныг олгуулж, өргөдлийг шийдвэрлэв.

1.1.3. Нийгмийн хамгаалал, хүүхэд, гэр бүлийг дэмжих чиглэлээр хүргэсэн үйлчилгээ

“Эрүүл мэндийн үйл ажиллагаа явуулж буй эмч нарын нэгдсэн холбоо” ТББ болон Сөүл хотын “Seoul jump medical center”-тэй хамтран эрүүл мэндийн анхан шатны үзлэг, оношилгоог 2026 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж визгүй 6 иргэнийг хамруулан, жороор олгох эм олгон 930,000 воны эмнэлгийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэв.



БНСУ дахь Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын үйлчилгээний төв нь Боловсролын Ерөнхий газар болон СБД-ийн Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран тус улсад эцэг эхээ даган ирж, сургууль завсардсан хүүхдүүдийг алсын зайн цахим сургалтад хамруулан Суурь боловсролын болон Бүрэн дунд боловсролын

гэрчилгээ олгох “Боловсрол нөхөн олгох” сургалтын бүртгэлийг эхлүүлж, 2 хүүхэд бүртгээд байна.



Зорилтот төсөл болох "Учралын баяр"-ын ажлын албатай хамтран ажиллаж БНСУ-д G-1 буюу эрүүл мэндийн зорилгоор оршин сууж байгаа иргэдийн хүүхдийг хамруулахаар тохиролцон G-1 визтэй 2 гэр бүлийн 2 хүүхэд, E-9 виз буюу хөдөлмөрийн гэрээт иргэдийн 2 гэр бүлийн 2 хүүхдийг хамруулах хүсэлтийг тус төсөлд илгээсэн.

1.1.4. Ур чадвартай ажилчны (E-7-4) виз руу шилжихийг дэмжих үйлчилгээ

Хөдөлмөрийн гэрээт ажилчны E-9 визээс ур чадвартай ажиллах хүчний E-7-4 виз руу шилжсэн иргэдийн судалгаанд тайлант хугацаанд 1 иргэнийг шинээр бүртгэсэн.

E-7-4 визний асуудлаар “E-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал групп үүсгэн визээ сольсон, солих хүсэлтэй иргэдийг нэгтгэж байгаа ба гишүүдийн тоо 1328 байна.

Мэдээлэл сурталчилгааг идэвхжүүлэх зорилгоор Төвийн “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” фэйсбүүк хуудсаар ур чадвартай ажилтан гэр бүлээ урих талаарх мэдээллийг 2 удаа нийтэлсэн.

1.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

1.2.1. Өргөдөл, гомдлын дагуу олгуулсан мөнгөн дүн, үйлчилсэн иргэний тоо

Тоон мэдээллийн агуулга		Гүйцэтгэлийн тоон үзүүлэлт	
		Иргэн	Олгуулсан дүн (вон)
Хөдөлмөрийн гэрээт ажилчдад	1. Нутаг буцах зардал	8	4,000,000
	2. Цалин, илүү цагийн хөлс	4	15,518,684
	3. Самсунгийн 13 дахь сарын цалин	9	42,265,380
	4. Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө	3	7,030,673
	5. Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	6. Гэнэтийн ослын даатгал		
	7. Гэнэт халагдсаны тэтгэмж		
	8. Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Бусад төрлийн визээр оршин суудаг иргэдэд	9. Олгогдоогүй хойшилсон цалин хөлс		
	10. 13 дахь сарын цалин	3	34,565,893
	11. Үйлдвэрлэлийн ослын даатгал		
	12. Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
Хууль бусаар оршин суудаг иргэдэд	13. Олгогдоогүй хойшлогдсон цалин хөлс	3	7,752,000
	14. 13 дахь сарын цалин	7	38,378,948
	15. Үйлдвэрлэлийн ослын даатгал		

	16.Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад		
	Нийт олгуулсан мөнгөн дүн/иргэн	**37**	**149,511,578**

1.2.2. Хүлээж авсан өргөдлийн шийдвэрлэлт

Нийт өргөдөл	Шинээр хүлээн авсан өргөдөл	**Шийдвэрлэлтийн байдал**			
		Хугацаанд нь шийдвэрлэсэн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэж буй
76	36	31	22	-	45

1.2.3. Үйлчилгээний төрөл, шийдвэрлэлт

	Үйлчилгээний төрөл	**Тоо**
1.	Самсунг даатгалын газраас 13 дахь сарын цалин болон нутаг буцах замын зардал авах материалыг бүрдүүлэн, даатгалыг олгуулах, нутаг буцахтай холбоотой зөвлөгөө, мэдээлэл өгөх	15
2.	Үйлдвэрээс авах 13 сарын цалингийн зөрүү бодолт хийх аргачлалыг танилцуулах, бодолт хийх, ажил олгогчоос нэхэмжлэн олгуулах	9
3.	Гэрээт ажилчдын ажлаас гарах өргөдөл гомдлын дагуу судлан, асуудлыг шийдвэрлэх	7
4.	Олгогдоогүй цалин хөлсний маргааныг шийдвэрлэж, цалин, хөлсийг олгуулах, зөвлөгөө, мэдээлэл өгөх	16
5.	Цалин, илүү цаг, амралтын хөлсийг бодох болон тооцоолох аргачлалын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	4
6.	Үйлдвэрлэлийн ослын тухай, осолд орсон иргэнийг ослын даатгалд хамруулж, ажилгүйдлийн тэтгэмж болон нөхөн олговрыг олгуулах	1
7.	Гэнэтийн ослын талаар мэдээлэл зөвлөгөө өгч, даатгалд хамруулж, нөхөн олговрыг олгуулах	
8.	Үндэслэлгүй болон ажил олгогчийн буруутай үйлдлээс шалтгаалан ажлын байр солих болон гэнэт халагдсан тохиолдолд бүрдүүлэх материал, гэнэт халагдсаны тэтгэмж, бусад тэтгэмжийг олгуулж, өргөдлийг шийдвэрлэх	7
9.	Хөдөлмөрийн гэрээ сунгах (1жил 10сар), тусгай болон тогтвортой нөхцөлөөр дахин ирэх, давтан гэрээ байгуулахтай холбоотой бүх төрлийн мэдээлэл, зөвлөгөө өгөх	6
10.	Бүх төрлийн аман болон бичгийн орчуулгын үйлчилгээ. Үүнд: БНСУ-ын Засгийн газрын байгууллага, Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, Хөдөлмөрийн хэлтэс, Төв бирж, Эрүүл мэндийн газар, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Үндэсний тэтгэврийн алба, Хөдөлмөр, халамжийн газар (Хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагатай холбоотой аман болон бичгийн орчуулга)	7
11.	Хөдөлмөрийн гэрээт иргэдийн хамрагдах даатгал (ЭМД, ГОД, ҮОД, НД)-ын талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	4
12.	Жилийн эцсийн тайлангаар ХАОАТ-ын буцаалт хэрхэн авах талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	
13.	Хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх газар (ХЭХЯ), Шүүхийн шатанд өргөдөл, гомдол гаргах асуудлыг шийдвэрлэх, Хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний төв, Хөдөлмөр халамжийн корпорац, Сөүлийн баталгаат цалингийн даатгалын газарт иргэний өргөдлийг дамжуулан өгч шийдвэрлэх	
14.	Монгол иргэдийн сайн дураар нутаг буцах мэдэгдэл гаргах, оршин суух хугацааг шалгах, сунгах хүсэлт гаргах, цаг авахад туслах	

15.	Визний ангилал солиулахад /Е9-өөс Е-7-4 виз рүү/ оноо цуглуулах, топик шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн сургалтад бүртгүүлэх талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх	5
16.	Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх	
17.	Хүүхэд, гэр бүл	4
18.	Бусад мэдээлэл, зөвлөгөө	22
19.	ХурДан төрийн цахим үйлчилгээ үзүүлэх	10
Үзүүлсэн үйлчилгээний тоо	Утсаар	92
	Цахимаар	11
	Танхимаар	14
	Нийт	117

ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

(Тайлант хугацаа 2026.09.01 - 2026.09.30)

2.1. Нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хэрэгжилтийг хангаж, нийгмийн даатгалтай холбоотой гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэх арга хэмжээ:

1) Хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажиллаж буй иргэдээс 20 иргэнийг Монгол Улсын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.
   - ❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:
     - 30 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
     - 5 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
     - 12 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

   Нийт 47 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2) БНСУ-д бусад төрлийн визтэй оршин суугч Монгол иргэдээс 41 иргэнийг сайн дурын даатгалд хамруулж, холбогдох программд бүртгэн, гэрээ байгуулсан.
   - ❖ Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ:
     - 23 иргэний гэрчилгээний хугацааг сунгасан;
     - 2 иргэнд дахин гэрчилгээ олгосон;
     - 32 иргэнд шинээр гэрчилгээ олгосон.

   Нийт 57 иргэнд чөлөөлөгдөх гэрчилгээ олгож, үйлчилгээ үзүүлсэн.

2.2. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх ажлын хүрээнд

Тайлант хугацаанд тус тасаг 273,199,726.00 төгрөгийн шимтгэлийн орлогыг төвлөрүүлсэн бөгөөд орлогын сарын төлөвлөгөө 62.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Шимтгэлийн 93.300,609.1 төгрөгийн орлогыг БНСУ-ын 3 банкны сангийн харилцах данснаас Нийгмийн даатгалын ерөнхий газрын Төрийн банкин дахь төвлөрүүлэх дансанд бүрэн шилжүүлж, сарын мэдээг хуульд заасан хугацаанд гаргасан. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Шилэн дансны тухай хуульд тус тус заасны дагуу тайлан, мэдээллийг Сангийн яамны холбогдох мэдээллийн санд байршуулсан.

2026 оны 09 дүгээр сард нийт 66 даатгуулагчийн 3 болон түүнээс дээш сарын 48,619,900.00 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Үүнд, албан журмын даатгалын 25 даатгуулагчийн 26,016,600.00 төгрөг, сайн дурын даатгалын 41 даатгуулагчийн 22,603,300.00 төгрөг байна.

2.3. Зөвлөгөө мэдээлэл, бусад үйлчилгээ

БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ:

- Тайлант хугацаанд Нийгмийн хамгааллын тухай Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийг танилцуулах, Үндэсний тэтгэврийн даатгалаас буцаан олголт авах талаар зөвлөгөө мэдээлэл өгөх үйлчилгээг утсаар 303, цахимаар 21, танхимаар 38 нийт 362 иргэн, даатгуулагчид үзүүлсэн.
- 2026 оны 09 дүгээр сарын 12-ний өдөр БНСУ-ын Инчеон хот дахь сургалтын төвд E-9 визээр БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр хөдөө аж ахуйн салбарт ажиллахаар ирж буй 5 иргэнд Нийгмийн даатгалын хууль тогтоомж, сайн дурын даатгалд хамрагдахын ач холбогдол, БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас хэрхэн чөлөөлөгдөх талаар сургалт зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.
- 2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Монгол тауны гадаа явуулын үйлчилгээ үзүүлсэн. Нийгмийн даатгалын холбогдох зөвлөгөөг 5 хүнд өгсөн. 15 хүнд нийгмийн даатгалын сурталчилгааны материал тараасан.
- 2026 оны 09 дүгээр сарын 26-ний өдөр Тэгүү хотын Гимху цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулж буй “WE LOVE MONGOLIA-7” Монголчуудын бэсрэг наадамд явуулын үйлчилгээ үзүүлж, 9 хүнд Монгол Улсын нийгмийн даатгалын талаарх зөвлөгөө мэдээлэл өгч, 30 гаруй тараах материал тарааж, 4 хүнийг сайн дурын даатгалд шинээр хамруулан ажилласан.
- БНСУ-д оршин сууж байгаа Монгол Улсын иргэдээс нийгмийн даатгалын талаарх ойлголт, даатгалд хамрагддаг эсэх талаарх 38 иргэнээс судалгаа авсан.

2.4. Нийгмийн даатгалын чиглэлээр гүйцэтгэсэн ажил (тоон дүнгээр)

Үйлчилгээ			Тоо	Өссөн дүнгээр
1.	Даатгалд шинээр хамруулсан	Албан журмын даатгал	20	268
		Сайн дурын даатгал	41	367
2.	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон *(Албан журмын даатгал)*	Шинээр	12	228
		Дахин	5	26
		Хугацаа сунгасан	31	268
3.	Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ олгосон *(Сайн дурын даатгал)*	Шинээр	32	205
		Дахин	2	41
		Хугацаа сунгасан	23	253
4.	Шимтгэлийн орлого төвлөрүүлэлт	Албан журмын даатгал	91,490,400.00	888,330,800.00
		Сайн дурын даатгал	181,709,326.00	1.574,274,886,01
		Нийт	273,199,726.00	2,462,605,686.01
5.	Гурав болон түүнээс дээш сарын шимтгэлийн авлага барагдуулалт	Албан журмын даатгал	26,016,600,00	258,939,928.00
		Сайн дур	22,603,300.00	197,726,631.00
6.	БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалын буцаан олголт	Нэхэмжилсэн	39,787,940,00	152,026,070,00
		Олгосон	0	131,253,410
		Буцаан олголт авсан хүний тоо	0	28

7.	Иргэдэд өгсөн зөвлөгөө, мэдээлэл	Утсаар	303	3027
		Цахимаар	14	217
		Танхимаар	38	535

ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА, ЯВУУЛЫН БОЛОН СЭТГЭЛЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

3.1. Сургалт сурталчилгаа, явуулын үйлчилгээ


Төвийн БНСУ дахь “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” сошиал хуудсанд 14, youtube сувагт 1, байгууллагын seoulcenter.mlsp.gov.mn цахим хуудсанд 12 мэдээлэл, зөвлөгөө нийтэлж сурталчилж, 50,764 иргэн мэдээлэл авахаар хандаж, 1079 удаа мэдээ мэдээллийг хуваалцсан байна.

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр үйлчилгээний салбарт ажиллахаар ирсэн 5 иргэнд ирсний дараах сургалтыг 2026 оны 9 дүгээр сарын 9-ний өдөр Ичон хот дахь сургалтын төвд танхимаар зохион байгуулж дараах агуулгын хүрээнд мэдээлэл өгөв. Үүнд:

- ХНХҮТ-ийн үйл ажиллагааны танилцуулга
- Цалин хөлс тооцох, ажлын байр солих талаар
- Үйлдвэрлэлийн ослын даатгал, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, ослоос урьдчилан сэргийлэх тухай
- Солонгос улсын хууль, журам, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар
- Суугаа орондоо дасан зохицоход анхаарах зүйл
- Сэтгэл зүйн зөвлөгөө мэдээлэл
- Ур чадвартай ажиллах хүчний E-7-4 визний талаар
- Солонгос хэлний сургалт, урьдчилсан үнэлгээ хийх шалгалтуудын хуваарь
- Хууль бусаар оршин суухын сөрөг тал, хуулийн дагуу оршин суухын давуу тал зэрэг болно.

Төвийн “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Монгол Тауны гадна талбайд БНСУ-ын “White E” шүдний эмнэлэгтэй хамтран зохион байгуулж, тус эмнэлгээс 15 иргэний шүдний рентген зураг авч, зөвлөгөө өгсөн. Өдөрлөгийн үеэр 14 иргэнд хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалтай холбоотой зөвлөгөө мэдээлэл өгч, 51 иргэнд гарын авлага түгээсэн.





Монгол тауны гадна талбайд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийн үеэр

БНСУ-ын Тэгүү хотын Гимху цэцэрлэгт хүрээлэнд 2026 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан “WE LOVE MONGOLIA-7” Монголчуудын бэсрэг наадамд оролцож иргэдэд хөдөлмөрийн харилцаа, Монгол Улсын нийгмийн даатгалын талаарх зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.





Тэгүү хотод зохион байгуулагдсан “Явуулын үйлчилгээ”-ний үеэр

ХХҮЕГ-аас 2026 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт цахим сургалтад төвийн албан хаагчид хамрагдсан.

3.2. Хамтын ажиллагаа, төвийн зарим дотоод ажил

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир БНСУ-д айлчлахтай холбогдуулан хөтөлбөр боловсруулж, 2026 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албатай уулзалт зохион байгуулав. Уулзалтаар ахмад настны нийгмийн хамгаалал, тэтгэврийн тогтолцоотой холбогдуулан санал солилцож, Монгол Улсын Засгийн газар болон БНСУ-ын Засгийн газар хооронд байгуулсан “Нийгмийн хамгааллын хэлэлцээр”-ийг шинэчлэн хамтын ажиллагааны хүрээг өргөжүүлэхээр тогтсон.




Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир Монгол Улсаас БНСУ-д суух ЭСЯ-нд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албатай хийсэн уулзалт (2026.09.04)

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакирын БНСУ-д хийж буй айлчлалтай холбогдуулан Узбекстан улсын Ерөнхий сайдын харьяа Шилжилт хөдөлгөөний агентлагийн БНСУ дахь Төлөөлөгчийн газартай уулзах уулзалтыг зохион байгуулж, уулзалтаар харилцан туршлага солилцож, цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тогтов.





Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Т.Аубакир, Узбекстан улсын Ерөнхий сайдын харьяа Шилжилт хөдөлгөөний агентлагийн БНСУ дахь төлөөлөгчийн газартай хийсэн уулзалт (2026.09.04)

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаад нутаг буцаж буй Монгол Улсын иргэдэд бизнесийн дэмжлэг үзүүлэх төсөл хөтөлбөрийг хамтран зохион байгуулах чиглэлээр 2026 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр БНСУ-ын The Bridge International байгууллагатай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж ажиллав.





БНСУ-ын The Bridge International байгууллага, БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулав (2026.09.08)

Төвийн удирдлагаас БНСУ-ын Гадаад ажилчдыг дэмжих холбооны Зохион байгуулалт, удирдлагын хэлтсийн дарга Хён Юн Ильтэй 2026 оны 08 дугаар сарын 26-ны өдөр уулзаж, цаашид харилцан ойлголцлын санамж бичиг байгуулан хамтран ажиллах чиглэлээр санал солилцов.

2026 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр Төвийн удирдлага БНСУ-ын Нийгмийн бодлогын судалгааны хүрээлэнгийн захирал Пак Сүн Ильтэй уулзалт зохион байгуулж, цаашид нийгмийн хамгааллын хүрээнд хамтран ажиллах чиглэлээр санал солилцов.

Шинээр ирсэн гэрээт ажилчдын судалгаа, ур чадвартай ажилчдын судалгаа, нутаг буцаж буй иргэдийн судалгааны мэдээллийн санг шинэчлэв.

Хөдөлмөрийн гэрээт ажилчидтай тогтмол эргэх холбоотой ажиллах зорилтын хүрээнд 13 иргэнтэй утсаар холбогдож, нөхцөл байдлыг нь тодруулж, хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгсөн.

- - - oOo - - -